



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийцлийн аудитын тайлан

Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн
хөнгөлөлтөд олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүн



Эмийн үнийн хөнгөлөлтөд олгох санхүүжилт буурч,
үйлчилгээний хүртээмж муудсан, эмийн үнийн дээд
хязгаарыг барьж ажиллаагүйгээс үйлчлүүлэгчээс
эмийн үнийн зөрүүг нэмж авсан байна.

2017 он

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн: Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа Аудитын менежер Г.Наранбаяр Ахлах аудитор Ц.Батсайхан Аудитор М.Ундармаа 2017 оны 11 дүгээр сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7054-3156, 7054-3179, 7054-3151 дугаарын утсаар харилцана уу. Байгууллагын хаяг: ГСА Сүмбэр сум 3-р баг, Нутгийн удирдлагын ордон 2-р давхар “Б” корпус 208 тоот	Товчилсон үгийн тайлбар Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй Бүлэг 1 Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмж муудсан, оролцогч талууд хууль журамд заасан эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна. 1.1 Эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээ үзүүлэх эмийн сангуудыг холбогдох хууль, журмын дагуу сонгон шалгаруулсан байна. 1.2 Эмийн сангуудтай холбогдох хууль, журмын дагуу гэрээ байгуулж ажилласан боловч талууд гэрээний үүргээ биелүүлээгүй, 2017 оны эхний хагас жилд гэрээ дүгнэх ажил хийгдээгүй байна. 1.3 Эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээнд оролцогч талууд хууль, журамд заасан эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна. 1.4 Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж муудсан байна. 1.5 Даатгалын байгууллага нь эмийн үнийн хөнгөлөлтийн асуудлаар эмийн сан, даатгуулагч, эмч нарыг мэдээллээр хангах, сурталчлах, хамтран ажиллах талаар тодорхой ажил зохион байгуулаагүй байна. Бүлэг 2. Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлтөд олгох санхүүжилт буурч, төсвийг төлөвлөгдөөгүй зардалд зарцуулсан байна. 2.1 Эмийн үнийн хөнгөлөлтөд олгох төсвийг холбогдох үзүүлэлтүүдийг үндэслэн боловсруулж, батлуулаагүйгээс төсөв өмнөх оноос 30.5 хувиар буурч батлагдсан байна. 2.2 Эмийн сангуудад батлагдсан хуваарийн дагуу санхүүжилтийг олгоогүй, илүү, дутуу санхүүжүүлсэн байна. 2.3 Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлтөд олгохоор батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна. 2.4 Эмийн сангийн байгууллагууд эмийн үнийн дээд хязгаарыг барьж ажиллаагүйгээс үйлчлүүлэгчээс эмийн үнийн зөрүүг нэмж авсан байна.
---	--

Бүлэг 3 Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон эмийн үнийн хөнгөлөлтөд холбогдох хууль, журмын дагуу хяналт тавьж ажиллаагүй байна.

3.1 Өрх, сум, багийн эмч нар хөнгөлөлттэй эмийн жорын тайланг гаргаж ажиллаагүй байна

3.2 Аймгийн ЭМНДХ-ээс эмийн сангуудтай байгуулсан гэрээний дагуу 2017 оны эхний хагас жилд хяналт шалгалтыг хийгээгүй байна.

3.3 Эмийн үнийн хөнгөлөлт үзүүлж буй эмийн сангийн байгууллагуудад даатгалын болон бусад мэргэжлийн байгууллагаас хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Холбогдох байгууллагын санал

Холбогдох байгууллагаас ирүүлсэн саналд хийсэн тайлбар

Товчилсон үгийн тайлбар

[illegible]

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас Монгол Улсын Ерөнхий аудиторт 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

2. Аудитын зорилт

Аудитаар 2016 он, 2017 оны 3 дугаар улирлын байдлаар Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн хөнгөлөлтөд олгосон хөрөнгийн зарцуулалтад Нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудын дагуу аудит хийлээ. Үүнд:

1. Эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг хуулийн хүрээнд зохион байгуулсан эсэх
2. Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлтөд олгох хөрөнгийг үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай зарцуулсан эсэх
3. Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон эмийн үнийн хөнгөлөлтөд холбогдох хууль, журмын дагуу хяналтыг хэрэгжүүлсэн эсэх

3. Аудитын хамрах хүрээ

Аудитад аймгийн Эрүүл, мэнд нийгмийн даатгалын хэлтсийн Эрүүл мэндийн даатгалын сангаас жороор олгох эмийн үнийн хөнгөлөлтөд 2016 он, 2017 оны 3 дугаар улирлын байдлаар олгосон санхүүжилт, ажлын тайлан, мэдээ, төсвийн төлөвлөлт, зарцуулалт, бүртгэл тайлагналтай холбоотой анхан шатны баримтууд, гэрээт эмийн сангуудын холбогдох бусад баримт материалуудыг хамрууллаа.

4. Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг АДБОУС 100, 400, 4100, Төрийн хяналт, шалгалтын стандарт Нийцлийн аудитын гарын авлага, холбогдох журмуудыг ашиглахаас гадна холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, шаардлагатай мэдээ, судалгааг гаргуулан авч, харьцуулан шинжлэх, түүвэрчлэн шалгах, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх, санал асуулга авах зэрэг аудитын арга зүйг ашиглан, нотлох зүйл цуглуулж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

5. Үндсэн мэдээлэл:

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх Эрүүл мэндийн даатгалын зөвлөлийн 2011 оны 09-р сарын 27-ны өдрийн 03 тоот тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангаас зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх” журам, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 08 тоот тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн ерөнхий нэршлийн жагсаалт, үнийн дээд хязгаар, хэмжээг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2016 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/74 тоот тушаалаар “Эрүүл мэндийн даатгалын сангаас жороор эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх журам”-ыг тус тус баталсан байна.

Аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс Эрүүл мэндийн даатгалын сангаас жороор олгох эмийн үнийн хөнгөлөлтөд 2016 онд 5 эмийн санд 171,962.6 мянга, 2017 оны 3 дугаар улирлын байдлаар 7 эмийн санд 164,767.5 мянган төгрөгийг тус тус олгохоор төсөв батлуулж, гэрээ байгуулан ажилласан байна. Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр 2016 онд 12,413 иргэнд 171,073.5 мянга, 2017 оны 3 дугаар улирлын байдлаар 5,352 иргэнд 130,952.3 мянга төгрөгийн эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг үзүүлсэн байна.

6.Аудитын бүрэлдэхүүн

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, аудитын менежер Г.Наранбаяр үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ц.Батсайхан, аудитор М.Ундармаа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

7.Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл

Аудитын тайлан нь аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, түүнд хийсэн тайлбар, хавсралт гэсэн бүтцээр үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

Аудитын тайланг шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулж, санал авч, аудитын тайланг эцсийн хувилбараар боловсруулан баталгаажууллаа.

8. Хүндрэл бэрхшээл

Аудитын явцад АЭМНДХ-ээс аудитад шаардлагатай баримт материалуудыг цаг тухайд нь гаргаж ирүүлээгүй, эмч, ЭМД-ын хамралт, орлого хариуцсан байцаагч, Эмийн бодлогын хэрэгжилт, эмийн чанар аюулгүй байдал, эмийн зохистой хэрэглээгээ, худалдан авах ажиллагаа, тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтнүүдийг аудитад бэлэн байлгаагүйгээс шаардлагатай ажилтнуудтай ярилцлагын тэмдэглэл хийх боломжгүй зэрэг аудитын үйл ажиллагаанд хүндрэл бэрхшээл учруулсан болно.

Эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг хуулийн хүрээнд зохион байгуулсан уу?

Бүлэг 1

Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж муудсан, оролцогч талууд хууль журамд заасан эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

1.1 Эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээ үзүүлэх эмийн сангуудыг холбогдох хууль, журмын дагуу сонгон шалгаруулсан байна.

Эрүүл мэндийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.11-д “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журмыг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах”, 16 дугаар зүйлийн 16.1.4-т “Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа, тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагаас тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хүртээмжийг нь харгалзан сонгон шалгаруулах үйл ажиллагааг энэ хуулийн 14.9.11-д заасан журмын дагуу зохион байгуулах” гэсэн заалтуудыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны 06 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын

төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ыг баталсан байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн даатгалын газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын 2016.05.13-ны өдрийн 3/129 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн дагуу аймгийн НДХ-ийн даргын 2016.06.02-ны өдрийн А/13 тоот тушаалаар сонгон шалгаруулах ажлын хэсгийг 7 хүний бүрэлдэхүүнтэй томилсон байна.

Сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аймгийн Нийгмийн хөгжлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Эрүүл мэндийн газрын эмийн бодлого хариуцсан мэргэжилтэн, Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч, Нийгмийн даатгалын хэлтсийн хяналт шалгалтын улсын байцаагч, эрүүл мэндийн даатгалын хяналтын эмч, магадлагч эмч, хэлтсийн үйл ажиллагааны нягтлан бодогч, иргэний төлөөллөөс оруулсан байна.

Журмын 2.2-т заасны дагуу комиссын бүрэлдэхүүнд мэргэжлийн холбоодын төлөөллөөс оруулаагүй бөгөөд комиссын бүрэлдэхүүнд орох шаардлагагүй хэлтсийн хяналт шалгалтын улсын байцаагчийг оруулан томилсон, мөн иргэний төлөөллөөр байгууллагын ажилтныг оролцуулсан нь хууль эрхзүйд нийцээгүй байна. Иймд цаашид сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүнийг журмын дагуу байгуулахыг зөвлөж байна.

Тус хэлтэс нь журмын 1.6-д заасны дагуу сонгон шалгаруулалт явуулах тухай зарыг 2016 оны 06 дугаар сарын 10-ны өдөр 7 эмийн санд албан бичгээр болон байгууллагын цахим хаягаар олон нийтэд ил тод мэдээлсэн байна.

Сонгон шалгаруулалтад аймаг, сумын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж буй 7 эмийн сангаас материал ирүүлсэн бөгөөд сонгон шалгаруулах ажлын хэсэг НДҮЗ-ийн 2016.03.25-ны 06 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын сонгон шалгаруулалтанд оролцох эрүүл мэндийн байгууллагад тавигдах шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлал”-ын 5 дугаар хавсралтын дагуу үнэлгээг өгсөн байна.

Сонгон шалгаруулалтад оролцогч байгууллагуудын баримт материалыг үнэлсэн байдлыг дараах хүснэгтээр харуулбал:

№	Эмийн сангийн нэр	Ерөнхий шалгуурын оноо				Тусгай шалгуурын оноо										Нийт оноо
		1.1	1.2	1.3	Авсан оноо	2.1	2.2	2.3	2.4	2.5	2.6	2.7	2.8	2.9	Авсан оноо	
1	Ансот	4	4	2	10	10	10	15	10	10	10	0	5	5	75	85
2	Говийн Сондор-1	4	4	2	10	0	10	15	10	10	10	0	5	5	65	75
3	Говийн Сондор-2	4	4	2	10	10	0	15	0	10	10	0	5	10	60	70
4	Их догшин	4	4	2	10	10	10	15	10	10	10	0	5	10	80	90
5	Оргил Дэнж	4	0	2	6	10	10	15	10	10	10	0	5	10	80	86
6	Сөдийн цэцэг	4	4	2	10	10	10	15	10	10	10	0	5	5	75	85
7	Эм импекс	4	4	2	10	0	10	15	10	10	10	0	5	10	70	80

Хүснэгтээс харахад: Эмийн сангууд ерөнхий шалгуур үзүүлэлтийг 94 хувьтай хангасан бол тусгай шалгуур үзүүлэлтийн 2.7-д “эмийн санд тавигдах нийтлэг шаардлага MNS 5260:2015”, 20.2-т “анхан шатны маягтуудыг хөтөлсөн байх” гэж заасныг тус тус бүрэн хангаагүй байна.

Сонгон шалгаруулалтад оролцсон 7 эмийн сангийн байгууллагыг журмын 3.2.2-т “Комиссын гишүүд ирүүлсэн материал бүртэй танилцаж, сонгон шалгаруулалтад орох байгууллагуудад тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлалын дагуу үнэлгээ өгөх” гэж заасны дагуу үнэлж, дүнг нэгтгэсэн байна.

Сонгон шалгаруулалтад оролцогч байгууллагуудын баримт материалыг үнэлсэн дүнг комиссын хурлаар хэлэлцэн шийдвэр гаргаагүй, зөвхөн шалгуур үзүүлэлтээр үнэлсэн хүснэгтэнд дарга, гишүүд гарын үсэг зурсан байна.

Сонгон шалгаруулалтын дүнг аймгийн ЭМНДХ-ийн даргын 2016.06.28-ны өдрийн 216 тоот албан бичгээр үнэлгээний хуудсыг хавсарган НДЕГ-ын дэргэдэх Эрүүл мэндийн даатгалын газарт хүргүүлж, НДЕГ-ын даргын 2016.07.08-ны А/152 тоот тушаалын 6 дугаар хавсралтаар тус аймагт 7 эмийн сангаар ЭМДС-гаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээг орон нутагт үзүүлэхээр баталсан байна.

Сонгон шалгаруулалтын баримт материалыг архивын нэгж болгон үдэж архивлаагүй байна.

Энэ нь НДҮЗ-ийн 2016.03.25-ны 06 тоот тогтоолоор баталсан журмын хавсралт 3 дугаар зүйлийн 3.2.4-т “Сонгон шалгаруулалтын дүнг комиссын хурлаар хэлэлцэн, шийдвэр гаргана. Комиссын шийдвэрт дарга, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулан Эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэн нэгдсэн шийдвэр гаргуулах, 3.2.6-д “Сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан ажлын тайланг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд хүргүүлэх” гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд сонгон шалгаруулалтыг журмын дагуу зохион байгуулж, баримт материалын иж бүрдлийг хангаж ажиллах, баримт материалыг архивын нэгж болгон үдэж хадгалах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

1.2 Эмийн сангуудтай холбогдох хууль, журмын дагуу гэрээ байгуулж ажилласан боловч талууд гэрээний үүргээ биелүүлээгүй, 2017 оны эхний хагас жилд гэрээ дүгнэх ажил хийгдээгүй байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 16 дугаар зүйлийн 16.1.3-д зааснаар НДҮЗ-ийн дэргэдэх ЭМДСЗ-ийн 2012.01.09-ний өдрийн 01 тоот тогтоолоор баталсан загварын дагуу аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс нь 2016 онд 5, 2017 онд 7 эмийн сангийн байгууллагатай нэг жилийн хугацаатай гэрээ байгуулан ажилласан байна.

НДЕГ-ын даргын 2012 оны А/367 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар “Нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн байгууллага хооронд байгуулсан даатгалын гэрээг дүгнэх журам”, 3 дугаар хавсралтаар “Нийгмийн даатгалын болон эмийн сангийн хооронд байгуулсан даатгалын гэрээ дүгнэх үнэлгээний хуудас”-ыг тус тус баталсан байна.

Журмын 2.2-т заасны дагуу байгуулсан гэрээг жилд 2 удаа буюу 07 дугаар сарын 20, дараа оны 01 дүгээр сарын 20-ны дотор тус тус дүгнэхээр байна.

Тус хэлтэс нь 2016 онд 5 эмийн сангийн байгууллагатай гэрээ байгуулан ажилласан бөгөөд гэрээний биелэлтийг хагас жилээр буюу 2016 оны 06 сард, жилийн эцсийн биелэлтийг 2017 оны 01 сард тус тус дүгнэсэн байна.

Харин 2017 онд 7 эмийн сантай гэрээ байгуулан ажилласан боловч гэрээний биелэлтийг хагас жилээр дүгнээгүй журмыг зөрчсөн байна.

Эмийн сангуудтай байгуулсан гэрээний биелэлтийг дүгнэсэн байдлыг хүснэгтээр харуулбал:

№	Эмийн сангийн нэр	Гэрээ дүгнэсэн үнэлгээ	
		2016 он	2017 он
1	Их Догшин ХХК	91	-
2	Говийн сондор-1 ХХК	94	-
3	Говийн сондор-2 ХХК	89	-
4	Оргил дэнж ХХК	88	-

5	"Монгол эмипекс" ХХК-ний ГСА дахь салбар	93	-
6	"Сөдийн цэцэг" ХХК	-	-
7	"АНСОТ" ХХК	-	-

Хүснэгтээс харахад: Гэрээ байгуулсан эмийн сангууд 2016 онд 88-93 оноогоор үнэлүүлсэн бол 2017 оны эхний хагас жилийн байдлаар гэрээг дүгнээгүй байна.

НДЕГ-ын даргын 2012.12.05-ны өдрийн А/367 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн байгууллага хооронд байгуулсан даатгалын гэрээг дүгнэх журмын 5.1.1-д "Гэрээний биелэлт 80-100 оноогоор үнэлэгдсэн эрүүл мэндийн байгууллагатай даатгалын гэрээг үргэлжлүүлэн байгуулна" гэж заасан байна.

Гэрээг дүгнэхдээ журмын 3.2.1-д "Нийгмийн даатгалын байгууллагыг төлөөлж 3 хүртэл хүн /нийгмийн даатгалын хэлтсийн дарга, эрүүл мэндийн даатгалын тасгийн дарга буюу хяналтын байцаагч-эмчийг заавал оролцуулах/, 3.2.2-д "Эмийн санг төлөөлж 2 хүртэлх /эмийн сангийн эрхлэгч, жор баригч-эм зүйч/ 3.2.3-д "Даатгуулагчийн төлөөлөл, өрхийн эмч нарын холбооны төлөөлөл тус тус 1 хүн Нийгмийн даатгалын байгууллага эмийн сангийн хооронд байгуулсан гэрээг дүгнэх багийн бүрэлдэхүүн байна" гэснийг зөрчиж гэрээ дүгнэх бүрэлдэхүүнийг байгуулаагүй, зөвхөн НДХ-ийн 3 хүний төлөөллийн бүрэлдэхүүнтэй гэрээг дүгнэж ирсэн байна.

Иймд гэрээ дүгнэх журмын дагуу бүрэлдэхүүнийг томилж байх, журам зааврыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

НДЕГ-ын даргын 2013.10.25-ны өдрийн А/439 тоот тушаалаар "Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээ үзүүлэх эмийн сангийн хувийн хэрэг хөтлөх заавар"-ыг баталж, эмийн сангуудын хувийн хэргийн мэдээллийг шинэчилж, шинээр гэрээ байгуулан ажиллахыг аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарт даалгасан боловч нэг ч эмийн санд хувийн хэрэг хөтлөөгүй байна.

2016 онд даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах төсөвт НДҮЗ-ийн 2016.12.15-ны өдрийн 30 дугаар тогтоолоор тодотгол хийж, төсвийн санхүүжилт нэмэгдсэнээр төсвийн нарийвчилсан хуваарийг ЭМНДЕГ-ын дарга шинэчлэн баталсан боловч эмийн сангийн байгууллагуудтай байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй, гэрээний дүнгээс илүү санхүүжилт олгосон байна.

Энэ нь тус гэрээний заалт болон НДЕГ-ын даргын 2016.04.12-ны А/74 тоот тушаалаар баталсан "Эрүүл мэндийн даатгалын сангаас жороор олгох эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх журам"-ын 5.2.1-д "Нийгмийн даатгалын байгууллага нь эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх сонгон шалгаруулалтад тэнцсэн эмийн сантай, даатгуулагчдад эмийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээг байгуулан, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллах" гэснийг зөрчсөн байна.

1.3 Эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээнд оролцогч талууд хууль журамд заасан эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх журмын үйлчлэлд хамаарах оролцогч талууд нь хуульд заасан эрх, үүргээ дараах байдлаар хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Даатгуулагчийн эрх, үүргийн хувьд: НДЕГ-ын даргын 2016.04.12-ны өдрийн А/74 тоот тушаалаар баталсан "Эрүүл мэндийн даатгалын сангаас жороор

олгох эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 5 дугаар зүйлд заасан эрх үүргээ даатгуулагчид мэддэггүй байна.

Журмын 5.1.2-д “Даатгуулагч нь эмчийн бичсэн жорын хуудсанд он, сар, өдөр, овог нэр, регистрийн дугаар болон эмнэлэг, эмчийн нэр, түүний шифр, хувийн тэмдэг /тамга/ зэрэг мэдээлэл бүрэн эсэхийг хянах” гэж заасан боловч даатгуулагчид хууль журамд заасан эрх, үүргээ төдийлөн сайн мэддэггүй, зөвхөн эмч, эмийн сангуудын үүрэг мэтээр хүлээж авдаг байна. Аудитын явцад 3 сумын 200 иргэнээс авсан санал, асуулгын дүн дараах байдалтай байна.

ИРГЭДЭЭС АВСАН СУДАЛГАА



Санал асуулгын дүнгээс харахад: Иргэд Эрүүл мэндийн даатгал төлснөөр зөвхөн эмнэлгийн байгууллагаас үйлчилгээ авдаг гэсэн ойлголттой байгаа бөгөөд ЭМД-ын тухай хууль болон ЭМД-ын сангаас жороор олгох эмийн үнийн хөнгөлөлтийн талаарх мэдээлэл дутмаг, энэ талаар холбогдох байгууллагууд нь иргэдэд хангалттай мэдээлэл өгөх үйл ажиллагаа дутагдалтай байна.

Даатгалын байгууллагын эрх, үүргийн хувьд: Аймгийн ЭМНДХ нь НДЕГ-ын даргын 2016.04.12-ны өдрийн А/74 тоот тушаалаар баталсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас жороор олгох эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 5 дугаар зүйлд заасан эрх, үүргээс дараахь эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Үүнд:

- Журмын 5.2.1-д зааснаар Эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх сонгон шалгаруулалтанд тэнцсэн эмийн сантай, даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээ байгуулсан боловч 2017 оны эхний хагас жилд гэрээний биелэлтийг дүгнээгүй, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.
- Журмын 5.2.2-т заасны дагуу даатгуулагч, эмийн сан, эмч, жор баригч болон бусад холбогдох байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлтийг судлан үнийн хөнгөлөлтөнд хамаарах эмийн жагсаалт, үнийн дээд хязгаарыг тогтоох, өөрчлөхөд санал боловсруулан холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллаагүй, судалгаа хийгдээгүй байна.
- Журмын 5.2.3-т заасан Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох эмийн үнийн хөнгөлөлтийн зардлын төсвийн төслийг даатгуулагчийн тоо, өвчлөлийн байдал, эмийн үнэ, тусламж үйлчилгээний хүртээмж, өмнөх онуудын гүйцэтгэл, зөвшөөрөл бүхий эмийн сангийн тоо болон бусад холбогдох мэдээллийн талаар хангалттай мэдээллийн санг бий болгоогүй, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.

Үнийн хөнгөлөлт үзүүлэх эмээр үйлчлэх эрх бүхий эмийн сангийн эрх, үүргийн хувьд: Эмийн сангууд нь дээрх журмын 5.3.1-ээс 5.3.9, 5.3.11-ээс 5.3.13-т заасан эрх, үүргүүдийг биелүүлж, дараах үүргийг биелүүлж ажиллаагүй байна.

- Журмын 5.3.10-т “Эмийн сан нь даатгуулагчтай эмийн үнийн төлбөр тооцоог кассын болон бар кодын машинаар хийж, тасалбарыг 2 хувь /эмийн худалдааны нэршлээр/ хэвлэн даатгуулагчид нэг хувийг заавал олгоно” гэж заасан боловч энэ үүргээ хангалттай биелүүлээгүй байна.
- Журмын 5.3.14-т “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх жагсаалтад заасан эмийн үнийн дээд хязгаарыг мөрдөн ажиллах” гэснийг зөрчиж иргэдээс хөнгөлөлттэй үнээр худалдан авсан эмийн үнийн зөрүүг нэмж авсан байна.

Аудитын явцад эмийн сангийн үйл ажиллагаатай холбоотой иргэдээс авсан санал, асуулгын дүн дараахь байдалтай байна.

ИРГЭДЭЭС АВСАН СУДАЛГАА



Санал асуулгын дүнгээс харахад: Санал асуулгад 200 иргэн хамрагдсан бөгөөд иргэдийн 61.5 хувь нь үгүй, 35.5 хувь нь тийм гэж хариулсан бол 3 хувь нь хариулаагүй байна.

Даатгуулагчдад үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жор бичих эмчийн эрх, үүргийн хувьд: Эрх, сум, багийн эмч нар нь НДЕГ-ын даргын 2016.04.12-ны А/74 тушаалаар баталсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас жороор олгох эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.4-д заасан үүргээс дараах үүргүүдийг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- Журмын 5.4.1-д “Эмч эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн сангийн жорыг “эмийн жорын маягт, жор бичилт MNS 5376:2014 стандартын дагуу бичих”,
- Журмын 5.4.9-д “Сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч, багийн бага эмч нарт олгох жорын маягтыг кодлон тодорхой тоо, ширхэгээр хүлээлгэн өгч, улирал бүр тооцоо нийлэн, эмийн жорын бичилт, эм олголтод хяналт тавьж ажиллах”

Аудитын явцад сумдын Эрүүл мэндийн төв болон Өрхийн эмнэлгийн жор бичих эрхтэй эмч нарын жорын маягтыг хэрхэн ашиглаж, тайлагнаж байгаа байдалтай танилцахад шинээр батлагдсан журам, заавартайгаа бүрэн танилцаагүй, мэдээлэлгүй байлаа.


Даатгуулагчид эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдлийг хуваалцах, эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд хүргэх замаар эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах

зорилгыг биелүүлэхийн тулд талууд харилцан нарийн уялдаатай ажиллах шаардлагатай байна. Иймд даатгалын байгууллага болон эмийн сангийн байгууллагууд, жор бичигч эмч нарт холбогдох хууль, журамд заасан үүргээ хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

1.4 Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж муудсан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээ нь чанартай, хүртээмжтэй байгаа эсэх талаар иргэдээс авсан санал асуулгын дүн болон хөнгөлөлттэй үнээр олгож буй эмийн нэр төрөлд хийсэн судалгааг үндэслэн дүгнэлт өгөхийг зорилоо.

Аудитын явцад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлж буй 7 эмийн сангуудаас гаргуулан авсан хөнгөлөлттэй үнээр олгосон эмийн судалгааг графикаар харуулбал:



Графикаас харахад: НДҮЗ-ийн 2016.03.25-ны өдрийн 08 тоот тогтоолоор батлагдсан ЭМДС-аас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх 25 бүлгийн эмийг түүвэрлэн үзэхэд иргэдийн дийлэнх нь цусны даралт бууруулах, элэг цөсний үйл ажиллагаанд нөлөөлөх элэг хамгаалах, халдварын эсрэг эм бэлдмэлийг голлон хөнгөлөлттэй үнээр авдаг байна.

Аудитын явцад Шивээговь, Баянтал сумдын эрүүл мэндийн төв, Сүмбэр сумын Энхтусдэм өрхийн эмнэлгийн эмчийн жор бичилт болон холбогдох байгууллагуудтай хэрхэн хамтарч ажилладаг талаар мэдээлэл авч холбогдох заавар журмыг танилцууллаа. Эмч нар сарын эхний өдөр эмнэлэг дээр үүссэн иргэдийн урт дараалалд хөнгөлөлттэй жор бичдэг боловч жор бичүүлсэн иргэн бүр тухайн хөнгөлөлтөнд хангалттай хамрагдаж чаддаггүй учраас гомдол маш ихээр гардаг байна.

Говьсүмбэр аймгийн Сүмбэр, Шивээговь, Баянтал сумын нийт 200 иргэдийг санал, асуулгад хамруулахад дараах санал хүсэлтийг ирүүлсэн байна. Үүнд:

- Эмийн хөнгөлөлтөнд хамрагдахын тулд өглөө 4-5 цагаас эхлэн эмийн сангийн гадаа дараалал үүсгэн зогсдог
- Жорд бичигдсэн эм эмийн санд байхгүй, өөр үнэтэй эм авах санал тавьдаг эсвэл хөнгөлөлттэй эмийн төсөв дууссан гэсэн шалтгаанаар ард иргэдийг чирэгдүүлдэг
- Санхүүжилтийг нэмэгдүүлж, сарын турш жигд хүртээмжтэй эмийг олгох
- Эмийн үнийн тариф эмийн сангуудад өөр өөр байдаг
- Эмийн үнийн дээд хязгаараас давсан үнээр эмээ худалдаалдаг
- Иргэдэд тэгш үйлчилдэггүй
- Эмийн зохистой хэрэглээний талаар мэдээлэл муу байдаг
- Өндөр настангууд хөнгөлөлттэй үнээр үйлчлүүлэхэд хүндрэлтэй
- Хөнгөлөлттэй үнээр эм авсан иргэдийн судалгааг нийтэд ил тод харуулдаг байх
- Говийн сондор хэвлэгдсэн баримтнаасаа илүү мөнгө авдаг
- Баянтал дахь Говийн сондор эмийн сан цагийн хуваарийн дагуу ажилладаггүй
- Эмийн сангууд нэхүүлж байж баримтаа хэвлэж өгдөг

Санал асуулгаас дүгнэхэд эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээ нь иргэдэд хүртээмжтэй биш байгаа нь харагдаж байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 30.5 хувь нь эмийн үнийн хөнгөлөлтөнд хамрагдсан бөгөөд төрөөс үзүүлж буй энэ үйлчилгээнд тогтмол хамрагдах боломжгүй болохыг тайлбарлаж байсан юм. Судалгааг графикаар харуулвал:

ИРГЭДЭЭС АВСАН САНАЛ, АСУУЛГА



1.5 Даатгалын байгууллага нь эмийн үнийн хөнгөлөлтийн асуудлаар эмийн сан, даатгуулагч, эмч нарыг мэдээллээр хангах, сурталчлах, хамтран ажиллах талаар тодорхой ажил зохион байгуулаагүй байна.

Аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсээс 2017 онд төрийн болон аж ахуйн нэгж байгууллагуудад Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулах сургалт явуулсан гэх боловч сургалтад хамрагдсан иргэдэд эмийн үнийн хөнгөлөлтийн талаар мэдээлэл өгсөн, иргэдтэй мэдээлэл солилцсон талаар тайлан байхгүй байна.

Мөн иргэдээс авсан санал асуулгын дүнгээс харахад судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 67 хувь нь эмийн үнийн хөнгөлөлтийн талаар мэдээлэл авч байгаагүй, 33 хувь нь ихэвчлэн ойр дотны эмийн хөнгөлөлтөд хамрагддаг иргэдээс мэдээлэл авдаг гэж хариулсан байна.

Энэ нь НДҮЗДЭМДЗ-ийн 2011.09.27-ны 03 дугаар тотоолоор баталсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх журмын хавсралтын 5 дугаар зүйлийн 5.3.2-д “Эмийн үнийн хөнгөлөлтийн асуудлаар даатгуулагч, эмийн сан, өрх, сум багийн эмч нарыг мэдээллээр хангах сурталчлах” гэснийг зөрчсөн байна.

Иймд холбогдох журмын заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлтөд олгох хөрөнгийг үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай зарцуулсан уу?

Бүлэг 2

Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлтөд олгох санхүүжилт буурч, төсвийг төлөвлөгдөөгүй зардалд зарцуулсан байна.

2.1 Эмийн үнийн хөнгөлөлтөд олгох төсвийг холбогдох үзүүлэлтүүдийг үндэслэн боловсруулж, батлуулаагүйгээс төсөв өмнөх оноос 30.5 хувиар буурч батлагдсан байна.

Тус хэлтэс нь ЭМДС-гаас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх зардлын төсвийг төлөвлөхдөө эмийн сангуудаас төсвийн саналыг хүлээн авч нэгтгэдэг боловч төсвийн санал нь үндэслэлтэй төлөвлөгдсөн эсэх, холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг үндэслэн боловсруулж байгаад хяналт хийдэггүй байна. Тухайлбал: 2017 онд “Говийн сондор-1” ХХК 124,800.0 мянган төгрөгөөр төсвийн саналаа ирүүлсэн боловч 84,000.0 мянгаар, “Сөдийн цэцэг” ХХК, “АНСОТ” ХХК-иудаас төсвийн төлөвлөлт ирүүлээгүй байхад “АНСОТ” ХХК-ийн төсвийг 40,000.0 мянган төгрөгөөр нэгтгэж ЭМНДЕГ-т хүргүүлсэн байна. Энэ нь ямар шалтгаанаар төсвийн саналыг нэмж, хасаж байгаа нь тодорхойгүй байгаа бөгөөд холбогдох журам, зааврыг баримтлан ажиллаагүй байна.

2016-2017 оны эмийн үнийн хөнгөлөлтийн зардлын төсвийн төлөвлөлт, батлагдсан төсвийг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөгөөр/

Д/д	Эмийн сан	2017 он		Зөрүү	2016 он		Зөрүү
		Төлөвлөлт	Батлагдсан		Төлөвлөлт	Батлагдсан	
1	Их Догшин ХХК	84,000.0	32,000.0	52,000.0	48,300.0	48,075.0	225.0
2	Говийн сондор-1 ХХК	124,800.0	40,400.0	84,400.0	55,315.0	62,100.0	-6,785.0
3	Говийн сондор-2 ХХК	17,168.4	5,200.0	11,968.4		12,112.5	-12,112.5
4	Оргил дэнж ХХК	65,000.0	20,000.0	45,000.0	31,800.0	28,750.0	3,050.0

5	"Монгол эмипекс" ХХК-ний ГСА дахь салбар	40,000.0	14,400.0	25,600.0		20,925.0	-20,925.0
6	Сөдийн цэцэг ХХК		4,000.0	-4,000.0			0.0
7	АНСОТ ХХК		4,000.0	-4,000.0			0.0
Нийт дүн		330,968.4	120,000.0	210,968.4	135,415.0	171,962.5	-36,547.5

Хүснэгтээс харахад: Эмийн үнийн хөнгөлөлтөд олгох зардлыг 2016 онд төлөвлөсөн дүнгээс 36,647.5 мянган төгрөгөөр илүү, 2017 онд 210,968.4 мянган төгрөг дутуу баталсан, өмнөх оны батлагдсан төсөвтэй харьцуулахад 30.2 хувиар буюу 51,962.5 мянган төгрөгөөр бууруулсан нь төсвийг үндэслэлтэй батлуулж чадахгүй байгааг харуулж байна.

Энэ нь НҮЗДЭМНДЗ-ийн 2011.09.27-ны 03 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн сангаас зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1-д “Нийгмийн даатгалын байгууллага нь энэ журмын 4.2-т заасан жагсаалтыг хүлээн аваад эрүүл мэндийн даатгалын сангаас олгох эмийн үнийн хөнгөлөлтийн зардлын төсвийн төслийг аймаг, нийслэл дүүргийн даатгуулагчийн тоо, өвчлөлийн байдал, эмийн үнэ, тусламж үйлчилгээний хүртээмж, өмнөх оны санхүүжилтийн гүйцэтгэл, хөнгөлөлттэй эмээр үйлчлэх зөвшөөрөл бүхий эмийн сангийн тоо болон бусад холбогдох үзүүлэлтийг үндэслэн боловсруулж, батлуулна” гэснийг зөрчсөн байна.

Иймд Эмийн сангуудаас эмийн үнийн хөнгөлөлтөд олгох зардлын төсвийн саналыг холбогдох журмын дагуу гаргуулан авах, ирүүлсэн төсвийн саналд дүн шинжилгээ хийж, төсвийг үндэслэлтэй боловсруулан батлуулж байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2.2 Эмийн сангуудад батлагдсан хуваарийн дагуу санхүүжилтийг олгоогүй, илүү, дутуу санхүүжүүлсэн байна.

Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т “Нийгмийн даатгалын байгууллага нь даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг төсвийн сарын хуваарийг үндэслэн гүйцэтгэлээр тооцож олгох бөгөөд Нийгмийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан гэрээний дагуу зардлын урьдчилгаа төлбөр олгож болно” гэж заасан байна.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс нь Эрүүл мэндийн даатгалын сангаас жороор олгох эмийн үнийн хөнгөлөлтөд 2016 онд 5 эмийн санд 171,962.6 мянга, 2017 оны 3 дугаар улирлын байдлаар 7 эмийн санд 90,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус олгохоор төсөв батлуулж, гэрээ байгуулан ажилласан байна.

Эмийн сангуудтай байгуулсан даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх худалдан авах гэрээний 4.6-д “Нийгмийн даатгалын байгууллага нь даатгуулагчид үзүүлсэн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг төсвийн сарын хуваарийг үндэслэн урьдчилгаа олгож болох бөгөөд үлдсэн төлбөрийг нэхэмжлэлийг шалгасны дараа гүйцэтгэлээр тооцож олгоно” гэж заасан байна.

Эмийн сангуудад олгох төсвийн санхүүжилтийг НДҮЗ-ийн тогтоолоор батлахдаа тооцоо судалгаагүй, төсвийг 7 эмийн санд харилцан адилгүй хуваарилан баталсан байна. Үүнээс шалтгаалан Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэж чаддаггүй, эмийн сангуудад ачаалал үүсгэж иргэдэд хүндрэл учруулдаг, санхүүжилт нь хүрэхгүй байгаагаас шалтгаалж үйлчлүүлэгч бүх эмийн сангаар үйлчлүүлэх нөхцөл байдал үүсдэг, жоронд бичигдсэн эмээ бүрэн авч чаддаггүй зэрэг байдал бий болж байна.

Иймд эмийн үнийн хөнгөлөлтөд олгох санхүүжилтийг баг, сум, хүн амын тоо, өвчлөлийн байдал, эмийн үнэ, тусламж үйлчилгээний хүртээмж, өмнөх оны санхүүжилтийн гүйцэтгэл зэргийг үндэслэн эмийн сангуудад жигд хүртээмжтэй, эрх тэгш, шударга зарчмыг баримтлан хуваарилж байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн сангийн байгууллагуудад гүйцэтгэлээр 2016 онд 12,413 иргэнд 171,073.5 мянга, 2017 оны 3 дугаар улирлын байдлаар 5,170 иргэнд 92,732.3 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг үзүүлсэн байна.

2016 он, 2017 оны 3 дугаар улирлын байдлаар эмийн үнийн хөнгөлөлтөд олгох зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэлийг эмийн сан тус бүрээр хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөгөөр/

Д/д	Эмийн сан	2017 оны 03-р улирал			2016 он		
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	Их Догшин ХХК	24,000.3	26,520.9	-2,520.6	48,075.0	48,074.1	0.9
2	Говийн сондор-1 ХХК	30,300.3	34,719.7	-4,419.4	62,100.0	74,105.3	-12,005.3
3	Говийн сондор-2 ХХК	3,899.7		3,899.7	12,112.5		12,112.5
4	Оргил дэнж ХХК	15,000.3	15,954.3	-954.0	28,750.0	27,986.8	763.2
5	"МЭИК"-ийн Говьсүмбэр салбар	10,800.0	9,496.6	1,303.4	20,925.0	20,907.3	17.7
6	Сөдийн цэцэг ХХК	2,999.7	3,001.6	-1.9			0.0
7	АНСОТ ХХК	2,999.7	3,039.2	-39.5			0.0
Нийт дүн		90,000.0	92,732.3	-2,732.3	171,962.5	171,073.5	889.0

Хүснэгтээс харахад: Эмийн сангуудад санхүүжилтийг олгохдоо 2016 онд батлагдсан төсвийн хуваариас 889.0 мянган төгрөг дутуу, 2017 оны 03 дугаар улирлын байдлаар 2,732.3 мянган төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон байна.

2016 онд “Говийн сондор-1” ХХК-д 12,005.3 мянган төгрөг илүү, “Говийн сондор-2” ХХК-д 12,112.5 мянга, “Оргил дэнж” ХХК-д 763.2 мянга, “МЭИК”-ийн Говьсүмбэр салбарт 17.7 мянган төгрөг тус тус дутуу олгосон бол, 2017 оны 3 дугаар улирлын байдлаар “Их Догшин” ХХК-д 2,520.6 мянга, “Говийн сондор-1” ХХК-д 419.4 мянга, “Сөдийн цэцэг” ХХК-нд 1.9 мянга, “АНСОТ” ХХК-нд 39.5 мянга, “Оргил дэнж” ХХК-д 954.0 мянга, нийт 3,935.4 мянган төгрөгийн санхүүжилтийг батлагдсан төсвийн хуваариас илүү, “МЭИК”-ийн Говьсүмбэр салбарт 1,303.4 мянга, “Говийн сондор-2” ХХК-д 3,899.7 мянган төгрөгийг тус тус дутуу олгосон байна.

Үүнээс харахад жил бүр “Говийн сондор-2” ХХК-д төсөв батлуулсан боловч санхүүжилтийн гүйцэтгэлийг “Говийн сондор-1” нэрээр тайлагнаж ирсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2.”Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэснийг зөрчсөн тул холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Иймд төсвийн хуваарийн дагуу санхүүжилтийг олгож, өглөг авлага үүсгэхгүй ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2.3 Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлтөд олгохоор батлагдсан төсвийг төлөвпөгдөөгүй зардалд зарцуулсан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлтийн зардалд 2016 онд 12,413 иргэнд 171,073.5 мянга, 2017 оны 3 дугаар улирлын байдлаар 5,170 иргэнд 92,732.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

НДҮЗ-ийн 2017.01.07-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор “Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх, 5 хүртэлх насны хүүхдийн ууж хэрэглэх эмийн жагсаалт, үнийн дээд хязгаар, хөнгөлөлтийн хэмжээ”-г баталж, тус тогтоолын дагуу эмийн сангуудад нийт 19,588.1 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Уг санхүүжилтийг олгохдоо тайланд онд үйлчилгээ үзүүлэх гэрээний үнийн дүнд багтаан тооцож олгосон байна.

Санхүүжилтийн зарцуулалтыг эмийн сан тус бүрээр хүснэгтээр харуулбал:

№	Эмийн сангийн нэр	Хүүхдийн тоо	Олгосон санхүүжилтийн дүн
1	“Их Догшин” ХХК	140	2,456.6
2	“МЭИК”-ийн Говьсүмбэр салбар	86	1,572.7
3	“АНСОТ” ХХК	131	612.2
4	, “Сөдийн цэцэг” ХХК	35	620.9
5	“Говийн сондор”-1 ХХК	430	7,915.3
6	“Говийн сондор”-2 ХХК	139	4,185.2
7	"Оргил дэнж" ХХК	150	2,225.2
Нийт дүн		1111	19,588.1

Дээрх тогтоолын 3-т “Тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан эрүүл мэндийн даатгалын сангаас олгох эмийн үнийн хөнгөлөлтийн 2017 оны төсвийн сарын хуваарьт өөрчлөлт оруулах, 5 хүртэлх насны хүүхдийн ууж хэрэглэсэн эмийн үнэд үзүүлсэн нийт хөнгөлөлтийн хэмжээгээр эрүүл мэндийн даатгалын зардлын төсөвт тодотгол хийх”-ийг Сангийн сайд, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдад үүрэг болгосон боловч 2017 оны 03 дугаар улирлын байдлаар төсөвт тодотгол хийгээгүй, эмийн үнийн хөнгөлөлтөд олгох санхүүжилтийг төлөвлөгдөөгүй зардалд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэснийг зөрчсөн байна.

НДҮЗ-ийн 2016.12.25-ны өдрийн 32 тоот тогтоолын хавсралтаар “Элэгний С вирусын эсрэг эмийн жагсаалт, үнийн дээд хязгаарыг хөнгөлөх хэмжээ”-г баталж, хөнгөлөлттэй эмээр үйлчлэх эрхийг аймгийн хэмжээнд ” Их догшин” ХХК, “МЭИК”-ийн Говьсүмбэр салбар, “Оргил дэнж”ХХК гэсэн 3 эмийн санд ЭМНДЕГ-ын шийдвэрээр олгож, 2017 оны төсөвт нийт 92,732.3 мянган төгрөгийг баталсан боловч НДЕГ-аас эмийн сан тус бүрээр хуваарилсан нарийвчилсан төсвийн хуваарийг баталж ирүүлээгүй байна.

2017 оны 03 дугаар улирлын байдлаар 74,767.5 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсанаас гүйцэтгэлээр “Их догшин” ХХК 80 хүнд 16,800.0 мянга, “МЭИК”-ийн Говьсүмбэр салбар 102 хүнд 21,420.0 мянга, нийт 38,220.0 мянган төгрөгийн эмийн үнийн хөнгөлөлт үзүүлж, санхүүжилтийг олгосон байна.

Иймд эмийн сангуудтай байгуулсан гэрээний үүргийг зөрчихгүй байх, тайлант онд нэмэлт үйлчилгээ үзүүлж байгаа тохиолдолд эрх бүхий байгууллагын шийдвэрийг гаргуулан авах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2.4 Эмийн сангийн багууллагууд эмийн үнийн дээд хязгаарыг барьж ажиллаагүйгээс үйлчлүүлэгчээс эмийн үнийн зөрүүг нэмж авсан байна.

Аймгийн ЭМНДХ-ийн Магадлагч эмч, эрүүл мэндийн даатгалын хяналтын албан тушаалд Э.Цэрэнтогтох 2016.01.19-2016.10.20 хүртэл, Б.Бат-Өлзий

2016.12.05-2017.09.20 хүртэл тус тус ажиллаж, 2016 он, 2017 оны 03 дугаар улирлын байдлаар хөнгөлөлттэй эмээр үйлчилсэн даатгуулагчдын жагсаалтад тавьсан хяналт шалгалтаар 2016 онд 331 хүний 1,186.3 мянга, 2017 оны 03 дугаар улиралд 62 хүний 1,089.0 мянга, нийт 2,275.3 мянган төгрөгийн зөрчлийг илрүүлж, санхүүжилтийг хасаж тооцсон байна.

Эмийн үнийн хөнгөлөлт үзүүлж буй эмийн сангууд нь НДҮЗ-ийн 2016.03.25-ны өдрийн 08 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн ерөнхий нэршлийн жагсаалт, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-г баримтлан ажиллаагүйгээс үйлчлүүлэгч буюу иргэдээс эмийн үнийн зөрүүг нэмж авсан байна.

Энэ нь даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээний 3 дугаар зүйлийн 3.5-д “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жагсаалт, хөнгөлөх хувь хэмжээнд”-нд заасан үнийн дээд хязгаарыг хэтрүүлэн даатгуулагчдад эм олгохыг хориглоно”, Эрүүл мэндийн даатгалын сангаас жороор олгох эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх журмын 5.3.14-д “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх жагсаалтад заасан эмийн үнийн дээд хязгаарыг мөрдөж ажиллах” гэснийг тус тус зөрчсөн байна

Тухайлбал: “МЭИК”-ийн Говьсүмбэр салбар нь 2016 онд 5,763.7 мянга, 2017 оны 03 улирлын байдлаар 3,439.4 мянган төгрөгийн алдагдлыг хүлээн зөвшөөрч санхүүгийн тайландаа бүртгэсэн байхад бусад эмийн сангууд нь алдагдлаа үйлчлүүлэгчээс нэмж авсан байна.

Эмийн сангуудаас үйлчлүүлэгчээс нэмж авсан үнийг зөрүүг НДҮЗ-ийн 2016.03.25-ны өдрийн 08 дугаар тогтоолоор баталсан журмаар эмийн нэр, төрлийг хэтэрхий олон болгосон, мөн тус жагсаалтаар баталсан эмийн үнэ нь Улаанбаатар хотын эмийн бөөний төвүүдэд зарж буй эмийн бөөний үнээр батлагдсанаас шалтгаалан эмийн сангууд алдагдлаа даатгуулагчаас нэмж авахад нөлөөлж байна гэсэн тайлбарыг өгч байна.

Иймд Нийгмийн даатгалын байгууллагаас холбогдох журам, зааварт өөрчлөлт оруулах, нөхцөл байдлын дүн шинжилгээ, судалгаа хийж, саналыг бэлтгэн эрх бүхий байгууллагуудад саналаа уламжилж ажиллахыг зөвлөж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон эмийн үнийн хөнгөлөлтөд холбогдох хууль, журмын дагуу хяналтыг хэрэгжүүлсэн үү?

Бүлэг 3

Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон эмийн үнийн хөнгөлөлтөд холбогдох хууль, журмын дагуу хяналт тавьж ажиллаагүй байна.

3.1 Өрх, сум, багийн эмч нар хөнгөлөлттэй эмийн жорын тайланг гаргаж ажиллаагүй байна

Аймгийн Эрүүл мэндийн газар нь ЭМДС-гаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жор бичих эмчийн нэрсийн жагсаалт, кодыг эмч өөрчлөгдөх тухай бүрт тушаал гаргаж, Нийгмийн даатгалын байгууллагад албан тоотоор хүргүүлэн ажиллаж ирсэн байна.

Аймгийн ЭМНДХ-ээс 2016 онд Эрүүл мэндийн газрын эмийн мэргэжилтэнд хөнгөлөлттэй эмийн жорын хуудас 24,000 ширхгийг олгосон гэх боловч тус эмийн мэргэжилтний тайлангаар 17.000 ширхэгийг орлого авч, сум, өрх, багийн эмчид

олгосон, 2015 онд олгосон 7000 жорын хуудсыг материалын тайланд 2016 онд олгосноор зөрүүтэй тайлагнасан байна.

2016 онд хөнгөлөлттэй эмээр үйлчлэх жорын хуудас хүлээн авсан эмч нар жорын тайланг гаргаагүй, сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч болон ЭМГ, ЭМНДХ-ээс шат шатны хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Стандарчиллын үндэсний зөвлөлийн 2016.11.24-ний өдрийн 52 дугаар тогтоолоор эмийн жорын маягт, жор бичилтийн MNS 5376:2016 стандарт батлагдсанаар аймгийн ЭМНДХ-ээс хөнгөлөлттэй эмийн тусгай жорын хуудсыг олгоогүйгээс өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төв нь өөрсдийн эмийн жорыг хуудсыг байгууллагын тамга тэмдэг, кодыг дарж баталгаажуулан хөнгөлөлттэй эмийг бичиж байгаа боловч жорын хуудасны орлого, зарлагын тайланг гаргаагүй байна.

Жорын хуудас бичих эрх бүхий эмч нар тайланг тухай бүр гаргаагүйгээс хичнээн үйлчлүүлэгчдэд хэдэн төгрөгийн хөнгөлөлттэй эмийн жор бичиж олгосон нь тодорхойгүй, бичигдсэн жорын хуудсаар үйлчлүүлэгч бүрэн үйлчилгээ авсан эсэх, жор бичих эрхтэй эмч жор бичсэн, жорыг үнэн зөв бичихэд хичнээн жорын хуудас зарлагдсан эсэхэд хяналт тавих боломжгүй болгож, ямарч хяналтын тогтолцоогүй байна.

Энэ нь НДҮЗДЭМДЗ-ийн 2011.09.27-ны 03 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4-т “Сумын эмнэлгийн эрхлэгч нь багийн бага эмч нарт олгох жорын маягтыг кодлон тодорхой тоо, ширхэгээр хүлээлгэн өгч, улирал бүр тооцоо нийлэн, эмийн жор бичилт, эм олголтод хяналт тавьж ажиллана”, НДЕГ-ын даргын 2016.04.12-ны А/74 тоот тушаалаар баталсан “Эрүүл мэнд, даатгалын сангаас жороор олгох эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.4.9-д “Сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч нь багийн бага эмч нарт жор олгох жорын маягтыг кодлон тодорхой тоо, ширхэгээр хүлээлгэн өгч, улирал бүр тооцоо нийлэн, эмийн жор бичилт, эм олголтод хяналт тавьж, ажиллах, 5.4.10-т “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жорын маягтыг стандартын дагуу хэвлүүлэх, ашиглах” гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд эмийн жорын хуудасны ашиглалтад хяналт тавьж ажиллаагүй, үнэт цаасны тайлан гаргаагүй холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж, эмийн жорын маягтыг стандартын дагуу хэвлүүлэх, жорын маягтын тооцоог улирал болон жор бичих эмч солигдох бүрд хийж хэвших зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

ЭМГ-ын Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 4.9-д заасан “Эм, эмнэлэгийн хэрэгслийн тухай хууль, Мансууруулах бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийг хангах, зайлшгүй шаардлагатай эмийн хангамж, хүртээмжийг сайжруулах эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх ажлыг эрчимжүүлнэ” гэсэн ажлын хүрээнд Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад хяналт, үнэлгээ хийх ажлын удирдамжийг ЭМГ-ын даргаар батлуулж, 5 эмийн сангийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, “МЭИК”-ийн Говьсүмбэр салбарт 10, “Говийн сондор”-1 ХХК-д 9, “Их догшин-2” ХХК-д 8, “АНСОТ” ХХК-д 5, “ЭКО” эмийн санд 7 зөвлөмжийг тус тус өгч, зөвлөмжийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлын тайланг 2017.12.01-ний дотор ирүүлэхээр зөвлөмж хүргүүлсэн байна.

3.2 Аймгийн ЭМНДХ-ээс эмийн сангуудтай байгуулсан гэрээний дагуу 2017 оны эхний хагас жилд хяналт шалгалтыг хийгээгүй байна.

Аймгийн ЭМНДХ нь 2016 онд 5, 2017 онд 7 эмийн сантай даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээг байгуулж, гэрээний

4 дүгээр зүйлийн 4.10-д “Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч, мэргэжилтэнгүүд хариуцсан эрүүл мэндийн байгууллагын өмнөх 2 жилийн гэрээний дүн, явцын хяналт дээр үндэслэн хариуцсан байгууллага дээр хагас жил тутам очиж явцын хяналт хийн, хавсралт 2-т заасан үнэлгээний хуудсаар дүгнэж, үр дүнг тооцон ажиллана” гэж заасан байна. Гэрээнд заасны дагуу 2016 онд гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж үнэлгээг өгсөн боловч 2017 оны эхний хагас жилд гэрээний биелэлтийг дүгнээгүй байна.

Аймгийн ЭМНДХ-ийн дарга нь 2017 оны 04 дүгээр сарын 27-нд эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээ үзүүлж буй эмийн сангуудад гэрээний явцын хяналт шалгалт хийх тухай удирдамжийг баталсан боловч хяналт шалгалтын бүрэлдэхүүн тус хяналт шалгалтыг хийгээгүй бөгөөд байгууллагын удирдлагын зүгээс гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй, үүрэг даалгавар биелүүлээгүй холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцоогүй байна.

Энэ нь тус гэрээний заалт болон НДЕГ-ын даргын 2016.04.12-ны А/74 тоот тушаалаар баталсан “Эрүүл мэнд даатгалын сангаас жороор олгох эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 5.2.1-д “Нийгмийн даатгалын байгууллага нь эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх сонгон шалгаруулалтад тэнцсэн эмийн сантай, даатгуулагчдад эмийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээг байгуулан, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллах” гэснийг зөрчсөн байна.

Иймд гэрээний үүргээ биелүүлж, журмын дагуу гэрээг хугацаанд нь дүгнэх, тухайн жилийн ажлын төлөвлөгөөнд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулахаар тусгаж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.3 Эмийн үнийн хөнгөлөлт үзүүлж буй эмийн сангийн байгууллагуудад даатгалын болон бусад мэргэжлийн байгууллагаас хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлтөд олгосон хөрөнгийн зарцуулалтад байгууллагын дотоод хяналт болон бусад мэргэжлийн байгууллагаас 2016 он, 2017 оны 03 дугаар улирлын байдлаар хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Аудитаар нийт 130,361.9 мянган төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгч, хариуцлага тооцуулах хугацаатай албан шаардлага хүргүүллээ.

ДУГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. Сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аймгийн Нийгмийн хөгжлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Эрүүл мэндийн газрын эмийн бодлого хариуцсан мэргэжилтэн, Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч, Нийгмийн даатгалын хэлтсийн хяналт шалгалтын улсын байцаагч, эрүүл мэндийн даатгалын хяналтын эмч, магадлагч эмч, хэлтсийн үйл ажиллагааны нягтлан бодогч, иргэний төлөөллөөс оруулсан байна.
2. Сонгон шалгаруулалтад оролцогч байгууллагуудын баримт материалыг үнэлсэн дүнг комиссын хурлаар хэлэлцэн шийдвэр гаргаагүй, зөвхөн шалгуур үзүүлэлтээр үнэлсэн хүснэгтэнд дарга, гишүүд гарын үсэг зурсан, сонгон шалгаруулалтын баримт материалыг архивын нэгж болгон үдэж архивлаагүй байна.
3. 2017 онд 7 эмийн сантай гэрээ байгуулан ажилласан боловч гэрээний биелэлтийг хагас жилээр дүгнээгүй, гэрээ дүгнэх бүрэлдэхүүнийг байгуулаагүй, зөвхөн ЭМНДХ-ийн 3 хүний төлөөллийн бүрэлдэхүүнтэй гэрээг дүгнэж ирсэн байна.
4. НДЕГ-ын даргын 2013.10.25-ны өдрийн А/439 тоот тушаалаар “Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээ үзүүлэх эмийн сангийн хувийн хэрэг хөтлөх заавар”-ыг баталж, эмийн сангуудын хувийн хэргийн мэдээллийг шинэчилж, шинээр гэрээ байгуулан ажиллахыг аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарт даалгасан боловч нэг ч эмийн санд хувийн хэрэг хөтлөөгүй байна.
5. 2016 онд даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах төсөвт НДҮЗ-ийн 2016.12.15-ны өдрийн 30 дугаар тогтоолоор тодотгол хийж, төсвийн санхүүжилт нэмэгдсэнээр төсвийн нарийвчилсан хуваарийг ЭМНДЕГ-ын дарга шинэчлэн баталсан боловч эмийн сангийн байгууллагуудтай байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй, гэрээний дүнгээс илүү санхүүжилт олгосон байна.
6. Даатгуулагчид эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдлийг хуваалцах, эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд хүргэх замаар эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах зорилгыг биелүүлэхийн тулд талууд харилцан нарийн уялдаатай ажиллах шаардлагатай байна.
7. ЭМДС-аас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх 25 нэр, төрлийн эмийг түүвэрлэн үзэхэд иргэдийн дийлэнх нь цусны даралт бууруулах, элэг цөсний үйл ажиллагаанд нөлөөлөх элэг хамгаалах, халдварын эсрэг эм бэлдмэлийг голлон хөнгөлөлттэй үнээр авсан байна.
8. Иргэдээс авсан асуулгын дүнгээс харахад санал, асуулгад хамрагдсан нийт иргэдийн 67 хувь нь эмийн үнийн хөнгөлөлтийн талаар мэдээлэл авч байгаагүй, 33 хувь нь ихэвчлэн ойр дотны эмийн хөнгөлөлтөд хамрагддаг иргэдээс мэдээлэл авдаг гэж хариулсан байна.
9. Даатгалын байгууллага нь ЭМДС-гаас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх зардлын төсвийг төлөвлөхдөө эмийн сангуудаас төсвийн саналыг хүлээн авч нэгтгэдэг боловч төсвийн санал нь үндэслэлтэй төлөвлөгдсөн эсэх, холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг үндэслэн боловсруулж байгаад хяналт хийдэггүй байна.

10. Эмийн үнийн хөнгөлөлтөд олгох зардлыг 2016 онд төлөвлөсөн дүнгээс 36,647.5 мянган төгрөгөөр илүү, 2017 онд 210,968.4 мянган төгрөг дутуу баталсан, өмнөх оны батлагдсан төсөвтэй харьцуулахад 30.2 хувиар буюу 51,962.5 мянган төгрөгөөр бууруулсан нь төсвийг үндэслэлтэй батлуулж чадахгүй байгааг харуулж байна.
11. Эмийн сангуудад олгох төсвийн санхүүжилтийг НДҮЗ-ийн тогтоолоор батлахдаа тооцоо судалгаагүй, төсвийг 7 эмийн санд харилцан адилгүй хуваарилан баталсан байна.
12. НДҮЗ-ийн 2017.01.07-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор "Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх, 5 хүртэлх насны хүүхдийн ууж хэрэглэх эмийн жагсаалт, үнийн дээд хязгаар, хөнгөлөлтийн хэмжээг баталж, тус тогтоолын дагуу эмийн сангуудад нийт 19,588.1 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.
13. Эмийн сангийн багууллагууд эмийн үнийн дээд хязгаарыг барьж ажиллаагүйгээс үйлчлүүлэгчээс эмийн үнийн зөрүүг нэмж авсан байна.
14. Аймгийн ЭМНДХ-ээс 2016 онд Эрүүл мэндийн газрын эмийн мэргэжилтэнд хөнгөлөлттэй эмийн жорын хуудас 24,000 ширхэгийг олгосон гэх боловч тус эмийн мэргэжилтэний тайлангаар 17.000 ширхэгийг орлого авч, сум, өрх, багийн эмчид олгосон, 2015 онд олгосон 7000 жорын хуудсыг материалын тайланд 2016 онд олгосноор зөрүүтэй тайлагнасан байна.
15. 2016 онд хөнгөлөлттэй эмээр үйлчлэх жорын хуудас хүлээн авсан эмч нар жорын тайланг гаргаагүй, сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч болон ЭМГ, ЭМНДХ-ээс шат шатны хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
16. Аймгийн ЭМНДХ-ийн дарга нь 2017 оны 04 дүгээр сарын 27-нд эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээ үзүүлж буй эмийн сангуудад гэрээний явцын хяналт шалгалт хийх тухай удирдамжийг баталсан боловч хяналт шалгалтын бүрэлдэхүүн тус хяналт шалгалтыг хийгээгүй бөгөөд байгууллагын удирдлагын зүгээс гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй, үүрэг даалгавар биелүүлээгүй холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцоогүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын хэлтсийн удирдлагад:

- Сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүнийг журмын дагуу байгуулж, баримт материалын иж бүрдлийг хангаж ажиллах, баримт материалыг архивын нэгж болгон үдэж хадгалах
- Гэрээ дүгнэх журмын дагуу бүрэлдэхүүнийг томилж, журам зааврыг хэрэгжүүлэн ажиллах, эмийн сангуудад хувийн хэрэг хөтлөх
- Эмийн сангуудаас эмийн үнийн хөнгөлөлтөд олгох зардлын төсвийн саналыг холбогдох журмын дагуу гаргуулан авах, ирүүлсэн төсвийн саналд дүн шинжилгээ хийж, төсвийг үндэслэлтэй боловсруулан батлуулж байх
- Эмийн үнийн хөнгөлөлтөд олгох санхүүжилтийг баг, сум, хүн амын тоо, өвчлөлийн байдал, эмийн үнэ, тусламж үйлчилгээний хүртээмж, өмнөх оны санхүүжилтийн гүйцэтгэл зэргийг үндэслэн эмийн сангуудын ачааллыг тэнцвэржүүлэх, иргэдэд чирэгдэлгүй түргэн шуурхай үйлчлэх боломжийг бий болгох зорилгоор жигд хүртээмжтэй, эрх тэгш, шударга зарчмыг баримтлан хуваарилж байх
- Төсвийн хуваарийн дагуу санхүүжилтийг олгож, өглөг авлага үүсгэхгүй ажиллах
- Эмийн сангуудтай байгуулсан гэрээний үүргийг зөрчихгүй байх, тайлант онд нэмэлт үйлчилгээ үзүүлж байгаа тохиолдолд эрх бүхий байгууллагын шийдвэрийг гаргуулан авах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх
- Нийгмийн даатгалын байгууллагаас холбогдох журам, зааварт өөрчлөлт оруулах, нөхцөл байдлын дүн шинжилгээ, судалгаа хийж, саналыг бэлтгэн эрх бүхий байгууллагуудад саналаа уламжилж ажиллах
- Эмийн жорын маягтыг стандартын дагуу хэвлүүлэх, жорын маягтын тооцоог улирал болон жор бичих эмч солигдох бүрд хийж хэвших, эмийн сангийн байгууллагууд, жор бичигч эмч нарт холбогдох хууль, журамд заасан үүргээ хэрэгжүүлж ажиллах заавар зөвлөмж хүргүүлэх
- Гэрээний үүргээ биелүүлж, журмын дагуу гэрээг хугацаанд нь дүгнэх, тухайн жилийн ажлын төлөвлөгөөнд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулахаар тусгаж ажиллах
- Нийцлийн аудитаар илэрсэн алдаа дутагдлыг дахин гаргахгүй байх, өгөгдсөн албан шаардлагыг хугацаанд нь хэрэгжүүлж ажиллах

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ


**ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТЭС**
42011 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Чойр.
Утас/Факс: (976) 7054 3011

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

2017.11.21 № 489
талай _____ -ны № _____ -т

Эмийн сангийн тухай

Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон эмийн үнийн хөнгөлөлтийн зарцуулалт үр дүнд хийгдсэн Нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцан дараахь саналаа хүргүүлж байна.

1. 2016 онд Эмийн сангуудын санхүүжилт хүрэлцээ багатайгаас болж Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 30 дугаар тогтоолоор төсвийн тодотгол хийсэн шийдвэрийг хэрэгжүүлэн ажилласан болно.

Эмийн сангуудын гэрээний гүйцэтгэлийн 1-р сард дүгнэж ажилласан байна.


2. 2016 оны төсвийн төсөл, төлөвлөлтийг хийхдээ эмийн сангуудаас саналыг авч ажилдаа хэрэгжүүлнэ.

3. Эмийн сангуудад 2016 онд батлагдсан төсөв 889.0 мянган төгрөгөөр дутуу олгогдсон сан нь тодотгосон төсвийн санхүүжилт 12 дугаар сард он дуусахаас өмнө ирсэн учир гүйцэтгэл гараагүй. 2017 оны 03 дугаар улирлын байдлаар 2732.3 мянган төгрөгийг 11, 12 сарын санхүүжилтээс суутган тооцлоо.

4. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01 тоот тогтоолоор 0-5 насны хүүхдийн эмийн үнэнд 19558.1 мянган төгрөгийг зарцуулсан болно.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл болон ЭМНДЕГ-ын тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэн ажилласан учир зориулалтын бус зарцуулсан гэсэн дүгнэлтийг гаргуулахгүй хасаж тооцож өгнө үү.

Холбогдох бичиг баримтыг хавсаргав.

ДАРГЫН АЛБАНҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Б.АЮУШЖАВ



D: aji_chuhai/alban bichig A4/

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

Аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсээс ирүүлсэн саналтай танилцаад дараах тайлбарыг хийж байна.

Санал-4 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл болон ЭМНДЕГ-ын тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэн ажилласан учир зориулалтын бус зарцуулсан гэсэн дүгнэлтийг гаргуулахгүй хасаж тооцож өгнө үү.

Тайлбар: Саналыг хүлээн авч тайланд өөрчлөлт оруулав.